

# Манмин Мэдээ

№ 59 2018 оны 4 сарын 22



2018  
학생동계  
수련회



## “Хайрын хүч, Өөрчлөлтийн зам”

### Сургаал, залбирал, магтаалаар бялхсан “2018 Сурагчдын өвлийн кемп”

Өнгөрсөн 2018 оны 2-р сарын 22-ноос 24-ныг хүртэл Сурагчдын багаас зохион явуулж буй 2018 оны өвлийн кемп нь залбирлын хүчийг авч, ариун сүнсний бялхал болон баяр хөөрөөр дүүрсэн мөргөл гэх мэт ивээл дүүрэн хөтөлбөртэйгөөр болж өнгөрлөө.

Тус үйл ажиллагааны эхний өдөр 10 цаг 30-минутаас нээлтийн мөргөлөөр эхэлж, Сурагчдын багийг хариуцсан Ким Чан мин номлогч “Хайрын хүч” (Марк 10:27) гэсэн сэдэвт сургаалиар “Бурхан Аав, Эзэн, түүнчлэн хоньчиноос бидэнд үзүүлж өгсөн тэр хайрын хүчээр сэтгэлдээ шийдсэнчлэн өөрчлөлтийн үр жимс болохыг” чухалчилж байлаа.

Үдээс хойш 2 цаг 30-минутаас эхлэсэн сургалтын цагаар Манмин бүх салбар сүмийн ерөнхий удирдагч И Хи сон пастор “Сүнсний ертөнц” (Эхлэл 1:1) гэсэн сэдвийн дагуу сургаал айлдахдаа “Сүнсний ертөнц гэж оршин байдаг болохыг баттай мэдэж, итгэснээр бүх үйлсдээ зорилготой бөгөөд хувиршгүй сэтгэлээр дуулгавартай үйлсээр урагш давших талаар” онцлон өгүүлсэн юм.

Сургалтын дараа ахлах сургуулийн 2-р ангийн сурагч Ким Ха ёон эгч дүү нь “Итгэлийн амьдралын зөв зорилготой болж, өөрийгөө эргэн харах боломжтой болсон” гэж ярьсан

юм.

Хоёр дахь өдөр нь өглөө 11 цагт Сөүл дижитал спорт цогцолборт маш дулаан бөгөөд тохиромжтой цаг агаар дунд спортын тэмцээн болж өнгөрсөн юм. Дунд сургуулийн 2-р ангийн сурагч И Юу на эгч дүү “Өчигдөр л гэхэд цас бороо холилдож орж байсан ч тэргүүн пасторын залбирлаар маш дулаахан хаврын зөөлөн цаг агаар дунд бүх үйл ажиллагаа маш гоё боллоо” гэсэн юм.

Энэ өдрийн орой сурагчид маань 23:00-04:00 хүртэл болдог Баасан гаригийн оройн цуглаанд оролцсон юм. Уг мөргөлийн 1-р хэсэгт Сурагчдын багийн гишүүдээс бүрдсэн Назарет ариун хоор дууны баг бүжгийн хамтаар “Гэрэлтэх долгио” гэдэг магтан дуугаар Бурханд алдрыг өргөж сургаалийн цагт ч гэсэн сүмийн төв танхимийн энд тэндээс “Амеен” гэх сурагчдын дуу сонсогдож, бусад итгэгч нарт ч ивээл өгч байсан юм. 30-минутын завсарлага дуусч, сурагчид нэг дор цугларан индэрийн зогсоод, тусгай пайз барин гал халуунаар магтаалыг өргөж байлаа. Ахлах 3-р ангийн И Хе рим эгч дүү нь “Магтаалийг өргөмөгцөө ертөнцөөс мэдрэхээргүй аз жаргал, баяр хөөрийг авлаа” гэж гэрчилж байлаа.

Хамгийн сүүлчийн өдөр болох Хагас сайн өдрийн 15 цагт төв

сүмийн урлагын зөвлөлийн тэргүүн болох И Хи жин пасторын удирдсан “Магтаал хүндэтгэлийн цуглаан” болж өнгөрсөн юм. Энэ цуглааны үеэр И Хи жин пастор Бурханы хайрыг дамжуулмагцаа, Бурханд нандинаар хэрэглэгдэхийн тулд сайтар бэлтгэгдэж, дэлхийн гэрэл ба давс болохыг захиж байсан юм. Тэнгэрийн орны найдвар хүсэл тэмүүлэлээр дүүрэн манмин магтаалыг дуулан, сэтгэл хөдлөл, нулимс, түүнчлэн ундрах мэт баяр хөөрөөр дүүрэн цаг байлаа.

Ахлах 1-р ангийн И Жэ өн эгч дүү нь “Сурагчдын мөрөөдлөө биелүүлэх аргыг мэдүүлж өгсөн сургаал айлдагчын мэдэрч үзсэн Эзэний хайрыг бидэнтэй хуваалцах үед үнэхээр ивээлтэй байсан ба хүссэнээр бүжиглэн магтах нь маш аз жаргалтай байлаа” гэж гэрчилж байлаа.

Энэ өдөр орой 9 цагаас эхлэх “Даниел залбирлын цаг”-т мөн оролцсон юм. Манмин залбирлын хүрээлэнгийн хариуцагч И Буг ним удирдагчын залбирлын бялхам удирдлага ба пасторууд залбиралд тусалж өгсөнөөр Ариун Сүнсний гал буусан мэдрэмжийг авсан юм. Сурагчид “Цаг яаж өнгөрч байгааг ч мэдэлгүй залбирлаа”, “Харь хэлээр ярихыг хүсч

байсан ч залбирал удирдагч надад хийж өгөхөд чаддаг болсон”, “Дэлхийг ялан дийлэх хүч авлаа” гэх зэргээр гэрчилж байлаа.

Ахлах ангийн бүлгийн ерөнхий удирдагч Пэг Жи хёон эгч дүү нь “Бурхан Аав болон Эзэн, хоньчины нулимс ба хайрыг зүрх сэтгэлдээ илүү гүн суулган, заавал ивээл дотор гарч ирье гэсэн шийдсэн цаг байлаа. Амийн уг сургаалийг сонсч Бурханы хүч нөлөөгөөр өсч буй бид хаана ч явсан үлгэр жишээ болж, хайр хүртэм сурагчид болох болно” сэтгэлээ хуваалцсан юм.

Энэ удаагийн өвлийн кемпээр дамжуулан Ариун Сүнсний бялхалыг авч, Бурхан Аавын болон Эзэний агуу хайрын хүчийг авсан Манминий сурагчид хурдан үзэсгэлэнт өөрчлөлтийн үр жимс болохыг хүсэн бүх л алдар талархалыг Ариун гурвал Бурхандаа өргөн баръя.





# Зүүдэлсэн зүүдээ биелэнэ гэдэгт итгэсэнээр

“Итгэлээр, Иосеф нас барж байхдаа Израйлийн хөвгүүд дүрвэх тухай дурдаж, өөрийнх нь ясыг хаана тавихыг гэрээсэлсэн билээ” (Еврей 11:22).



И Жей руг пастор

Хэн ч гэсэн чин итгэлээр бүхнийг чадагч Бурханаас гуйвал ямар ч хүсэл биелэгдэхгүй байх нь үгүй юм. Иосеф нь Израйлийн өвөг Иаковын арван нэг дэх хүү бөгөөд, Бурханы өгсөн зүүдийг марталгүй итгэлээрээ биелүүлсэн хүн юм. Тэрээр ямар итгэлээр ийм ерөөлийг авсан байх вэ?

## 1. Иаковын хүү Иосефийн амьдрал ба түүний итгэлээр дамжуулан бидэнд өгөх сургамж

**Нэгдүгээрт, Хүн зовлон эдэлж байгаа нь ихэнхдээ өөрийн дутагдлаас болдог.**

Иаков нь хайртай эхнэр Рахелаас удаан хугацааны турш хүлээж байж олсон хүү Иосефоо бусад хөвгүүдээсээ илүү хайрласан байсан юм. Тансаг, олон өнгө хосолсон дээл өмсгөж, бусад ах нар ажил хийхээр гарахад ч хажуудаа авч үлдэх хэмжээний хүүгээ хайрладаг байлаа. Аав зөвхөн дүүг нь л ингэж онцгой хайрладаг нь сэтгэл гонсойлгодог ч бүр цаашлаад ах нарынхаа алдаа дутагдлыг аавдаа сэм сэмхэн ховлох нь ах нарын зөвүүцэлийг улам хөдөлгөж эцэст нь үзэн ядаж эхэлсэн юм. Хэдийгээр Иосеф нь буруу зүйлийг зүгээр өнгөрөөхгүй зөвт сэтгэлийн үүднээс үйлдэж байгаа ч Бурханы өмнө энэ ч гэсэн зөвт гэхээр үйлдэл биш юм.

Нэгэн өдөр Иосеф ах нарынх нь боосон сүрэл өөрийнх нь боосон сүрэлд мөргөж байна гэж өөрийн ярьж гайхуулсан байдаг. Бас хэд хоногийн дараа зүүдэнд нь нар,

сар, од өөрт нь мөргөж байна мөн л гайхуулсан юм. Мэдээж энэ зүүд нь Бурханы өгсөн сүнслэг зүүд байсан ба удаан хугацааны дараа түүнчлэн биелэгдсэн юм. Гэвч хэрэв Иосеф жоохон ухаалаг бөгөөд даруу байсан бол ах нарынхаа атаархалыг хөдөлгөлгүй чимээгүйхэн сэтгэлдээ хадгалах байсан байх.

Ийм өсвөр насны хүүхэд сайрхах, гайхуулах дуртай байдаг тул эргэн тойрныхоо хүмүүсийн сэтгэл санааг ажиглах ухаан мэдлэг дутсан юм. Ах нарын тавгүйтэл улам гүнзгийрснээр эцэст нь Иосефийг Мидианы худалдаачдад зарж орхисон юм. Хэдийгээр ах нар нь ч хорон сэтгэлтэй ч Иосеф ердийн үед даруухан сэтгэлээр ах нартаа үйлчилж, тэдний сэтгэлд нийцүүлж байсан бол ийм явдал болохгүй байх байлаа (1 Иохан 5:18). Түүнчлэн ийм хэцүү байдалд орох тохиолдолд өөрийн үүднээс дутагдалтай зүйл юу байв гэж эргэж харах нь чухал юм.

## Хоёрдугаарт, Жинхэнэ итгэлтэй хүн ямар ч байдалд санаагаар унадаггүй.

Өсвөр насандаа Египетэд боолоор худалдаж, амьдралын найдваргүй мэт болсон ч тэрээр огт санаагаар унаагүй юм. Бурхан өөрийг нь удирдаж байгаа гэсэн итгэл болон өөрт нь өгөгдсөн зүүдний дагуу эрхэм өндөр байр сууринд очих болно гэсэн найдвар байсан учир юм.

Бурхан Египтийн фараоны харуулын дарга Потифарын гэрт итгэмжтэйгээр үйлчилж байгаа Иосефийг тэр гэрийн даамал болгодог. Гэтэл өөртэй нь унтах гэж уруу татаж буй Потифарын эхнэрийн үгийг эсэргүүцсэнээр тэр эмэгтэй өөрөөр нь даажигнаж доромжлох гэлээ гээд нөхөртөө хэлж шоронд хориулдаг юм. Харин Иосеф ямар ч тайлбар, шалтаг хэлээгүй байдаг.

Заримдаа хүнд үе тохиолдох, өөрийнх нь мөрөөдөл биелэхэд дэндүү хол мэт санагдавч эцсээ хүртэл итгэлээрээ тэсч хүлээвэл Бурханы сорилтоор үзэсгэлэнтэй сайхан аяга болон гарах найдвар байдаг юм.

## Гуравдугаарт, Жинхэнэ итгэлтэй болвол итгэмжит байдлаар ертөнцийн хүнд ч хүлээн зөвшөөрөгдөнө.

Иосеф нь шоронд байхдаа ч санаагаар уналгүй Бурханы өмнө гэм

хийхгүйгээр үл барам маш цайлган бөгөөд итгэмжтэй, тууштайгаар үйлчлэн, зориулж гэрэл ба давсны үүргийг гүйцэтгэн хичээнгүйлэн Бурханыг баярлуулсан юм. Бурхан түүний явсан газар болгон, бүх талбарт хүлээн зөвшөөрөгдөж, шоронд байхдаа ч шоронгийн захирагчын хайрыг хүртэж, шоронгийн дотоод ажлуудыг Иосефт даатгасан байдаг.

Нэгэн өдөр хааны сөнч, болон талхчин Иосефийн хоригдож буй шоронд орж ирдэг. Тэд нэг өдөр тус тусдаа зүүд зүүдэлсэн бөгөөд энэ зүүдээ Иосефийг тайлж өгөхийг гуйж, түүний тайлсанчлан талхчин цаазаар авахуулж, харин сөнч дахин өөрийн ажилдаа эргэн орсон юм.

2 жилийн дараа Фараон өөрийн зүүдээ тайлж өгөх хүн хайхад, түүний сөнч Иосефийн тухай санал болгож, өөрт тохиолдсон явдлаа ярьж өгсөн юм. Фараоны өмнө Иосеф ирж “Энэ бол би биш, харин Бурхан Фараонд сэтгэлийг амрах хариу өгнө” гээд Бурханы талаар эхлээд ярьж өгөн, зүүдийг нь маш товч тодорхой тайлж өгсөн юм. Мөн энэ байдлаас хэрхэн ангижрах арга замыг хүртэл зааж өгдөг (Эхлэл 41:1-36). Тэгээд Иосеф боолоор худалдагдаад 13н жилийн дараа Египетийн ерөнхий сайд болон бүгдийг захирах болсон.

## Дөрөвдүгээрт, Бэрхшээл дунд ч найдвараа алдалгүй баяртай байх нь жинхэнэ итгэл юм.

Иосефийн зүүдний тайлалын дагуу Египетийн бүх нутагт 7н жил маш их ургац арвинтай, элбэг дэлбэг жил болж өнгөрөн түүний дараах 7н жил маш хатуу өлсгөлөн нэрвэсэн он жилүүд үргэлжилсэн юм. Гэвч Иосефийн ухаалаг шийдвэрийн ачаар өлсгөлөнгийн жилүүдэд сайн бэлдсэнээр Египет хангалттай хоол хүнстэй тэр он жилүүдийг давсан юм. Тэгээд Канаан нутагт амьдардаг Иосефийн ах нар Египетээс хоол хүнс худалдаж авахаар ирж, Египетийн ерөнхий сайд болсон Иосефт мөргөж хоол хүнс гуйдаг.

Тэгж л Иаковын гэр бүлийнхэн өлсгөлөнгөөс аврагдсан юм. Бага балчир Иосефийн зүүдэлсэн зүүдний дагуу энэ нь биелэгдсэн юм. Иосефийг боолоор худалдаж, шоронд хорих явдал нь ч Бурханыг харахад хамгийн богино хугацаанд энэ зүүдээ

биелүүлэх ерөөлийн цаг байсан юм. Ингэж дорд байдалд Иосеф нь улам даруу төлөв болж, хайр ба ачлалт уужим сэтгэлтэй болж, олон хүмүүсийг өөртөө өвөрлөдөг болов. Үргэлж Бурханыг түшиглэн, Түүнээс зуурч, итгэлээр өсөн өдий хэмжээнд хүрсэн юм. Хувиршгүй итгэлээр залбиран, өөрийн найдвараа алдалгүй итгэмжтэйгээр сорилтыг сайн туулан Бурхандаа алдрыг өргөсөн юм (Ром 5:3-4).

## 2. Итгэл ба найдвараар зүүдээ биелүүлсэн Иосеф

Иосеф нь өөрийг нь худалдсан ах нараа үзэн ядалгүй, зөвхөн Бурханы зүүдийг бодон түүнчлэн биелэгдэнэ гэдэгт итгэн бүх хүчээр зүтгэсэн юм. Бурхан аль эрт Абрахамд амласан зүйлд баттай итгэн энэ бүхний эцэст Канаан газар улс байгуулагдвал өөрийнх нь ясыг хамт авч явахыг гэрээсэлсэн байдаг (Эхлэл 50:24-25; Еврей 11:22).

Бурхан хүн төрөлхтөнийг дасгалжуулалт гэх том зорилгыг биелүүлэхийн тулд Израйл ард түмнийг сонгон, улс үндэстэн болгож, хүн төрөлхтөнийг аврах Есүсийг илгээх төлөвлөгөөг бий болгосон. Гэтэл Иосефийн үед Израйл ард түмэн сул дорой байсан тул эргэн тойрны хүчирхэг үндэстнээс хоргодох газар хэрэгтэй байсан, мөн цаашид 7н жилийн өлсгөлөн, гай зовлонгоос аврагдаж үлдэхийн тулд Египет гэх том улсын хоол хүнс, эд материал хэрэгтэй байсан юм.

Тиймээс Иосефийг түрүүлж Египет рүү илгээж, тэдний ерөнхий сайд болгож, түүгээр дамжуулан Израйлийн овог үндэстэнг Египет рүү удирдаж, өлсгөлөнгийн үед ч хэцүү байдлыг амсалгүй, түүнээс хойш 400 гаруй жилийн турш өсөж үржин том үндэстэн болсон юм. Иосеф нь Бурханы энэ төлөвлөгөөг хэдийн мэдсэн тул (Эхлэл 45:7-8) үхэх хүртлээ итгэлээ үзүүлсэн юм. Үүгээр дамжуулан бүх амьдралаараа яаж итгэлээрээ найдаж, зүүд мөрөөдлөө биелүүлдэг хүн байсныг харж болно.

Хайрт итгэгч та бүхэн, Иосефтай адил хувиршгүй итгэлээр сүр жавхлантай тэнгэрийн оронд орох тэр өдөр хүртэл хариулт ба ерөөлөөр дүүрэн байхыг Эзний нэрээр хүсэн ерөөе.

## Монгол Манмин Сүм

### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

### Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



**Хаяг:** Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг

**Утас:** 88107327, 91170773, 89737773

www.manmin.org  
www.gcntv.org



# Библид гардаг тоонуудад агуулагдсан сүнслэг утга учир

Библийн Эхлэл номоос Илчлэлт хүртэл уншиж байх явцад сүнслэг утга бүхий онцгой тоонууд гардаг. Жишээ нь, Мосегийн удирдамж дор Египетээс чөлөөлөгдсөн Израйлийн ард түмэн 40н жилийн турш цөлд амьдарч байгаад сүү балаар бялхсан Канаан нутагт очдог. Мөн Есүс Өөрийн үйлчлэлээ эхлэхээс өмнө 40 хоногийн мацаг барьдаг. Энэ мэт 4н “Газарын тоо”, “Зовлонгийн тоо”-г илэрхийлдэг бол 6 нь “Дасгалжуулалт”, “Махан биеийн орон зайд төгс утга”-г илэрхийлдэг юм.

Иохан номын 2-р бүлэгт Есүс Галилын Кана хотод нэгэн хуриманд уригдсан бөгөөд тэнд усыг дарс болгон хувиргасан анхны гайхамшигт үйлдэхдээ зургаан ширхэг чулуун ваарны амсарт нь тултал усаар дүүргэ гэсэн байдаг. Энэ гэм нүгэл үйлдсэн Адам Еден цэцэрлэгээс хөөгдсөний дараа зүрх сэтгэлийн талбайг хагалуулахаар хүн төрөлхтөний дасгалжуулалтын хугацаа 6 мянган жилийг илэрхийлж байгаа юм. Тэгвэл 3, 7, 12, 17 гэсэн тоонууд ямар утгыг илэрхийлж байгаа юм бол? Библи унших дөхөм бол тул үүний талаар үзэцгээе.

3

Нийлэмжит тоо бөгөөд “Төгс байдлын зохицол”-т тоо

‘Нийлэмжит’ гэдэг нь ‘Байр суурь, нөхцөл байдал, хүсэл зорилго нэгдмэл, зохицол’ гэсэн үг юм. Библид үзвэл бүтээгч Бурхан бол Ариун Аав, Ариун Хүү, Ариун Сүнс гурвын холбооны Бурханаар оршиж бүх хүн төрөлхтөнг авралд хүргэхийн тулд удирдаж байгаа юм.

Аврагч Эзэний үүргийг гүйцэтгэхийн төлөө хүний биеэр энэ газарт ирсэн Есүс 30 нас хүрмэгц 3-н жилийн үйлчлэлээ эхлэхийн өмнө Сүнсээр хөтлүүлэн явахдаа гурван ч удаа соригддог. Мөн загалмайд цовдлогдон нас бараад оршуулагдсан ч 3 хоногийн дараа үхлийн хүчийг ялан дийлж дахин амилсан байдаг.

Хуучин гэрээний үед Иона эш үзүүлэгч нь агуу хот Ниневе рүү очоод Бурханы шүүлт болох талаар тунхаглах зарлиг авдаг. Гэтэл Иона эш үзүүлэгч Бурханы хүсэлд дуулгаваргүй дагалгүй, Таршиш явах хөлөг онгоцонд сууж зугтан явах зуур далайн хар салхитай тулгарч, эцэст нь аварга том загасны гэдсэнд 3 өдөр юу ч идэж уулгүй, чин сэтгэлээсээ гэмшсэнээр аврагдаж чадсан юм.

7

‘Төгс тоо’ учир ‘төгс утгыг илэрхийлнэ.’

Библийн Эхлэл номонд гардаг тэнгэр газрын бүтээлийн түүхийг харвал долоо дахь өдөр бүтээлийн өдөр дууссан байдаг. Бурхан бүхнийг бүтээж дуусаад, долоо дахь өдрөө амарсан тул энэ өдрийг ерөөж, ариун болгов гэсэн байдгийг харж болох юм.

Илчлэлт номонд гардаг ‘Бурханы долоон сүнс’ нь 7-н төрлөөр хэмжиж ажигладаг Бурханы сэтгэл юм. Өөрөөр хэлбэл Бурхан хүн тус бүрийн зүрх сэтгэлийг ажиглахдаа өчүүхэн алдаагүй, маш тодорхой хардаг гэсэн үг юм.

Левит номын 4-р бүлэгт үзвэл гэмийн тахилыг өргөх үед өргөлийн цусыг 7-н удаа цацах тухай зарлигдсан ба энэ нь ‘Гэм нүглийг төгс цайруулана’ гэсэн утгатай юм. Арамын цэргийн жанжин Нааман нь уяман өвчнөөсөө эдгэрэх үед ч Иордан голд долоон удаа булхаж, Елиа эш үзүүлэгч Кармел ууланд асар их борооны хариултыг авахдаа ч 7-н удаа залбирсан байдаг. Есүс “Долоон удаа биш, дал дахин долоон удаа уучил” (Матай 18:22) гэж айлдсан нь “Төгс уучил” гэсэн утгатай юм.

12

‘Гэрлийн тоо’ тул Гэрэл болох Бурхан

Бурханы чухал хүсэл зорилгыг тайлбарлах үед элбэг тохиолдох гэрлийн тоо 12 нь сүнс талаар маш чухал утгыг илэрхийлдэг. Есүс “Өдөрт арван хоёр цаг байдаг биз дээ?” (Иохан 11:9) гэж айлдсаны дагуу өдрийн хамгийн гэрэлтэй үе 12 цаг байдаг шиг сүнс талаар жинхэнэ гэрэл болох бидний Эзэн Есүс ч гэрэл болон ирсэн тухай библид гардаг (Иохан 1:9).

Бурхан Иаковын 12 хөвгүүдээр ариун ард түмэн Израйль бий болж, Давидын үр удмаар Есүсийг энэ газарт илгээсэн юм. Мөн Есүсийн 12 шавиа сонгож, Эзэний үүргийг гүйцэтгэн, бүх дэлхийд сайн мэдээг тараасан юм.

Хамгийн үзэсгэлэнт тэнгэрийн орон Шинэ Иерусалим хотын 12 сувдан хаалганд Израйлийн 12 овгийн нэрийг, хотын хана, хэрэм дээр 12 элчийн нэрийг сийлээтэй байдаг ба үүнээс гадна библид ийм гэрлийн тоо маш гардаг юм.

17

‘Үйлддэг тоо’ бөгөөд үүнийг ‘Үр жимсийн тоо’ ч гэдэг

‘Бурханы хүсэл ба зорилгод нийцсэн Бурханы үүднээс Өөрөө гүйцэлдүүлэн биелүүлнэ’ гэсэн утгатай ба энэ нь Ноагын усан үеэрээс илэрхий харагддаг. Удаан хугацаанд хүлээж, нигүүлсэнгүй хайрын Бурхан гэм нүглээр дүүрэн тухайн үед хийсэн эцсийн сонголт байсан ч Ноагийн үеэс дахин эхлэх хүн төрөлхтөний дасгалжуулалтаар жинхэнэ үр хүүхдүүд олон гарч ирэхийг хүсэн хүлээж, зайлшгүй биелүүлнэ гэдгийн илэрхийлэл гэдэг.

Ноаг 600 нас хүрдэг жилийн 2-р сарын 17ны өдөр эхлэсэн усны үер 7-р сарын 17 ноос ус татарч эхлэсэн, Иаковын хүү Иосеф Египет рүү худалдагдах үедээ 17 настай байсан. Ялангуяа 17 гэдэг үр жимсийн тоо бөгөөд эцсийн үед маш олон хүмүүсийг өөрчлөн агуу зорилгыг биелүүлнэ гэсэн утга агуулдаг юм.

## Зураг

### 2018 Хүүхдийн багаас зохион явуулсан Тусгай сургалт

Маимин төв сүмийн Хүүхдийн баг нь хаврын амралтыг тохиолдуулан өнгөрсөн 2-р сарын 22ноос 24нийг хүртэл ‘Тусгай сургалт’-г зохион явуулж, Манминий балчир хүүхдүүд Эзэн дотор өөрсдийн мөрөөдөл ба зорилготой болох талаар ивээл дүүрэн цаг болж өнгөрлөө.



Эцсийн үед, Сүнс талаар сэрүүн баймаар байвал~ Бялхам бялхам залбирал хийх



Миний мөрөөдөл хүсэл, тэмүүлэл ‘Леви ажилтан (Сүмийн ажилтан)’ юу хийдэг вэ?



Миний гарын хоол ‘Өхөөрдөм бялуу’



Хүүхдийн цуглааны удирдагч Жу Мин геон номлогчтай хамтдаа ‘HAPPY POWER PRAISE’





Хятад Ви... (7 нас, эр) гэдэг энэ хүү 2017 оны 10-р сарын 2ны өдөр маш халуун усыг хүйтэн гэж бодон балгаснаас болж улаан хоолой нь түлэгдэж, маш их хорсолт болон хоол идэх боломжгүй болсон ба идсэн хоолоо ч бөөлжиж гаргадаг болсон юм.

Эмнэлэгт дурангийн шинжилгээ хийлгэж, түүний хариу нь улаан хоолой төгсгөл хэсгийн хана үрэвсэн шархалж үхжсэн байдалтай ба ходоодны шархлааны хүнд хэлбэр үүсч идээлсэн маш хүнд байдалд байгааг мэдсэн юм. Цус ихээр хуралдаж хавагнасан тул цус алдаж ч болзошгүй нөхцөлд байна гэсэн юм. 12-р сард рентген зураг авахуулахад улаан хоолойн төгсгөл хэсэг дэх уртын 7,3 см нь маш их нарийсалттай ба хамгийн нарийн хэсэг нь 1мм орчим болсон байлаа.

Энэ үйл явдлын дараа хүү нь дөрвөн сар гаруй огт юу ч идэлгүй, будааны зутан, сүү төдийхнөөр амь зогоох төдий байсан бөгөөд маш их турж,

### “Түлэгдлийн улмаас үүдсэн улаан хоолойн нарийсалтаас эдгэрсэн юм”



Залбирал авахын өмнө: Улаан хоолойн рентген зураг. Улаан хоолойн төгсгөл хэсэг 7,3 см нарийсалттай байгаа байдал. Илүү томруулсан байдал (Зүүн зураг). Ходоодны дээд хэсгийн ба улаан хоолойг дурангаар харахад шархлаа ба үхжил харагдаж байгаа байдал (Баруун зураг).

цэцэрлэгтээ ч явж чадахгүй байдалд хүрсэн юм. Хүүгийн ээж энэ тухай “Идэх юм нэхэж уйлагнан би яагаад юм идэж чадахгүй байгаа юм гэж уйлж чарлахад сэтгэл зүрх өмөрөн унаж байгаа юм шиг байлаа” гэсэн юм.

Түүний аав ээж нь хүүгээ зүгээр хараад суухыг хүссэнгүй. ‘Бурхан хамгаалж өгөөгүй шалтгаан нь юу байж болох вэ?’ гэж өөрсдийгөө эргэн харж, залбиран ‘Бүх хүнтэй эвтэй байгтун’, ‘Үзэн ядалт нь сүнс талын аллага’ гэсэн

сургаалиудыг сонссон ч эвтэй байж чадаагүй үзэн ядалтыг сэтгэлдээ тээж байснаа нэгд нэгэнгүй гэмшсэн юм.

Мөн И Жей руг тэргүүн пастортай уулзах сар шинийн уулзалтанд чин сэтгэлээсээ бэлдэж, 2018 оны 2-р сарын дундуур Солонгост биечлэн ирцгээн залбирал авсан юм. Тэгтэл тэр өдрийн орой маш гайхалтай зүйл болов. 4-н сар гаруйн турш зовиурлан байсан хүнд өвдөлт нь арилсан төдийгүй энэ хүү маань талх иддэг болсон байв. Халлелүяа!

Бага багаар биеийн байдал дээрдэж байгаа хүүгээ харахад эцэг эх нь яг л бүх ертөнцийг авсан мэт маш их баяртай байна. Тэрээр одоо өдөр бүр бага багаар хооллож, эргэн махалсаар урьдын дүр төрхөндөө орж, энэ жил бага сургуульд орж, хичээлдээ хэвийн явж байгаа юм.

Гайхамшигт эрх мэдэлт хүч чадлаар эдгээж өгсөн Ариун гурвал Бурхандаа бүх талархал ба алдрыг өргөө.

## “Хагалгаанд оролгүйгээр хөлийн шөрмөсний задралтаас эдгэрч одоо чөлөөтэй алхаж, гүйдэг болсон”

Жон Жү сон эгч дүү (16 нас, Дунд бүлгийн 3-р хэсэг)

2018 оны 2-р сарын 10ны өдөр шатаар бууж яваад зүүн талын хөл шагайгаараа бараг 90 градус нугаран хоромхон зуур доошоо суусан юм. Маш их өвдөж байсан тул босож ч чадалгүй, уйлаад байж байтал ээж маань гар утсаараа И Жей руг тэргүүн пасторын өвчний төлөө залбирлыг тавьж өгсөн юм. Залбирал авсаны дараа жоохон хөдлөх боломжтой болж, таяг тулан машин руу явсан юм.



Би гэртээ харьж явах зуураа хөлөө бэртээсэн тул би явж болохгүй газар явсан уу үгүй вү гэдгээ эргэн харж гэмших зүйлээ хайж байлаа. Тэр өдрийн орой тэргэнцэрт суугаад Даниел залбирлын цагт суухаар явж байхад Сурагчын багийн ахлагч Ким Чан мин номлогч олон ангит кино, юутубэ зэрэг хаяж чадаагүй дэлхийн зүйл байна уу гэдгээ эргэн хараарай гэсэн юм. Түүний дараа би гэмшсэн ч сэтгэл нэг л тавгүй байлаа.

Дараагийн өдөр болох Эзэний өдөр, Найзуудынхаа тусламжтайгаар тэргэнцэрт суун сүмдээ ирлээ. Зүүн хөлөөрөө газар тулан, хөлийн шагай хэсгээр маш хүчтэй өвдөж байсан ч ариун хоор дууны багт зогсож чадахгүйн гэсэн бодол огт орж ирээгүй юм. Илүү их өөрчлөгдөж чадаагүй гэх гэмших сэтгэл л байсан тул таяг тулаад ч хамаагүй ариун хоор дуундаа зогссон юм. Нэг хөл дээрээ


хамаг ачаалал өгөн магтаал дуу дуулахад хөл өвдөж бадайрч байсан ч тэссээр дуулж дуусгасан юм.

Сургаалийн дараа Тэргүүн пасторын өвчин эдгэрэх залбирал авахад бэртсэн хөлийн шагай хэсэгт хүч орж, эд эсүүд холбогдож байгаа мэт мэдрэмж төрсөн юм. Ямар байдалтайг нь мэдэхээр 12-ны өдөр эмнэлэгт үзүүлэл “Зүүн хөлийн тавхай ба шагайн холбоос шөрмөс” гэмтсэн болохыг мэдсэн юм. Ийм тохиолдолд ихэнхдээ хагалгаанд орох ёстой ч би Бурханаар эдгээлгэхийг хүссэн тул шагайн хөдөлгөөнийг хязгаарлах гипс л тавиулсан юм.

Ариун цэврийн өрөөнд орохдоо бусдын тусламжтайгаар орж, толгойгоо ээжээрээ угаалгадаг байлаа. Суга таяг тулдаг учраас мөр ба гар их өвдөж, нэг талын хөлөөрөө бүх биеийн ачаалал авах учир амархан ядарч байсан тул тэр орой гэртээ GCN телевизээр (www.gcnetv.org) Даниел залбиралд оролцсон юм. Тэгж байтал гэнэт нүднээс нулимс гарч энэ хугацаанд Бурхан Аавын хайрыг мартан амьдарч байсандаа маш их сэтгэл өвдсөн юм.

Тэргүүн пастор үргэлж зааж, захиж өгдөг ч урьдын адил сурагч гэдэг нэрийн дор ертөнцийн зүйлсийг хаяж чадаагүй байгааг хараад ямар их харамсаж байгаа бол гэж бодохоор сэтгэл өвдөн нулимсаар гэмшсэн юм. Тэгтэл сэтгэл тавирч хөнгөрөн тэргүүн пастортой сар шинээр уулзахад эдгэрч чадна гэсэн итгэл төрч эхэлсэн юм.

2-р сарын 14 тэргүүн пастортой уулзах сар



Залбирал авахын өмнө: Зүүн хөлийн шагайн холбоос шөрмөс задарсан байдал.

шинийн уулзалтанд оролцлоо. Сургаалийн дараа тэргүүн пастор нийтэд нь залбирал хийж өгсөн ба суга таягаа нэг гартай барин зогсож байгаа өөрийгөө ажиглалаа. Ямар өвдөлт зовиургүй болсон байв.

Тэргүүн пастортой гар барингаа “Хөл зүгээр болчихлоо” гэж гэрчлэхэд завгүй байсан ч гэсэн тэргүүн пастор доошоо бөхийн миний хөлөнд гар тавин чин сэтгэлээсээ залбирал хийж өгсөн юм. Ингэж байхад өөрчлөгдөж чадаагүй өөрийгөө харан их гэмшин нулимс унаж байлаа. Үүний дараа таяггүйгээр алхдаг болж гэртээ орохдоо шатаар хэвийн алхаж орсон юм. Халлелүяа.

Сурагчдын багийн өвлийн кемпд ч гүйж харайж, магтаал дуунд зогсоход огт өвдөхгүй, үйлчлэлийн ажлаа ч сайн гүйцэтгэж, спортын тэмцээний хөгжөөн дэмжигчээ ч сайн хийж чадсан юм. Эдгээж өгсөн Бурхандаа талархал ба алдрыг өргөн, залбирал хийж өгсөн тэргүүн пасторгаа талархалаа илэрхийлье.

### УБ Ариун баярт мэдээ чуулган

#### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

#### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

#### Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
www.manminnews.com  
e-mail: manminnews@manmin.kr  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин